Товъёг

| Д/д | Товч утга | Хуудасны тоо | Хуудасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын хууль | 4 | 2-5 |
| 2 | Ерөнхийлөгчийн зарлиг | 2 | 5-6 |
| 3 | Засгийн газрын тогтоол | 6 | 6-11 |
| 4 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 4 | 12-15 |
| 5 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | 1 | 16 |
| 6 | Ерөнхий сайдын албан даалгавар | 1 | 17 |
| 7 | Сайдын тушаал | 1 | 18 |
| 8 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал | 7 | 19-25 |
| 9 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар | 2 | 25-26 |

**ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭСТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ**

2022.12.08 Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс

| № | Шийдвэрийн нэр огноо, дугаар, агуулга Зүйл заалт | Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө, холбогдох эрхзүйн актын дагуу хийсэн ажлууд | Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч байгаа шалтгаан |
|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| ***Нэг. Монгол улсын хууль*** | | | | |
| 1 | 2022.04.29<br>Төрийн хэмнэлтийн тухай хууль<br><br>6.3 Энэ хуулийн 3.1-д заасан этгээд орон нутагт албан томилолтоор, хуульд заасан эрх бүхий этгээд газар дээрх хяналт шалгалтаар ажиллахад хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эсхүл төрийн болон орон нутгийн өмчийн авто тээврийн байгууллагаар үйлчлүүлэхээс бусад тохиолдолд автомашин ашиглахыг хориглоно.<br><br>11.1 Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гархад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй | НДЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 06/1234 тоот албан бичгийн дагуу хэлтсийн суудлын авто машиныг зам тээврийн хөдөлгөөнд оруулахыг зогсоож албан хэрэгцээнд ашиглахаа больсон ба тус хугацаанаас хойш тээвэр шатахууны 412.300 төгрөгийн зардлыг хэмнэн ажилласан байна.<br><br>2022 онд тус хэлтсээс тэтгэвэрт гарсан албан хаагч байхгүй бөгөөд тус зардлын ангиллаар зарцуулалт хийгдээгүй болно. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль<br>2021-12-17<br>Дугаар 2022.05.01 | Нийгмийн даатгалын хэлтсийн чиг үүрэг, нийгмийн даатгалын байгууллагын бүтэц зохион байгуулалт, хэрэглэгчийн лавлах утасны дугаар, хаяг байршил, и-мэйл хаяг, олон нийттэй харилцах мэдээлэл хүргэх фасебүүк холбоосыг вэб хуудсандаа иргэдэд ойлгомжтой байдлаар байршуулсан.<br>Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлан болон бусад холбогдох мэдээ нийт 151 мэдээлэл Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бусад холбогдох мэдээ нийт 163 мэдээллийг Шилэн данс системд хуулийн хугацаанд байршуулан ажилласан ба статистикийн газар 12 удаагийн мэдээ, Төрийн аудитын газраас 2021 оны Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр хүргүүлсэн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг 2 удаа хуулийн хугацаанд гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ба Аудитын шинэ цахим системд бүртгэн ажилласан байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Erdenet.mn, orhon.ndaatgal.mn хуудсууд дээр тус хэлтсийн албан хаагчдын овог нэр, албан тушаал, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийн оруулаад байна.<br>Тус хэлтэст 2022 оны байдлаар 349 өргөдөл ирсэний 42 тэтгэвэр, 42 тэтгэмж тогтоолгох өргөдөл, бусад 263 өргөдөл ирсэнийг бүртгэлд авч хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэж НДЕГ, аймгийн ЗДТГ-т шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам хүргүүлж цахим мэдээллийн санд бүртгэж ажиллалаа. Бусад асуудлаарх буюу нийгмийн даатгалын шимтгэлийн залруулга хийлгэх, регистрийн дугаар нэгтгүүлэх, илүү төлсөн мөнгө буцаан авах болон хэлтсийн албан хаагчдаас ирүүлсэн 263 өргөдөл байна.<br>Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн өдөр тутмын мэдээ мэдээллийг Шилэн дансны системд бүртгэсэнээс гадна Орхон аймгийн Статистикийн газарт нийгмийн даатгалын сангийн мэдээг 12 удаа хүргүүлэн ажиллалаа. Нийгмийн даатгалын байгууллагаас зохион байгуулах олон нийтийн аливаа арга хэмжээний талаарх мэдээ мэдээлэл, хөтөлбөрийг цахим хуудас, фэйсбүүк хуудсаараа дамжуулан иргэд даатгуулагч олон нийтэд орон зай цаг хугацаанаас үл хамааран цаг алдалгүй хүргэж ажиллаж байна.<br><br>Төрийн албаны тухай хуулийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд сул орон тоо гарсан тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлэн ажиллаж мөн олон нийтэд нээлттэйгээр байгууллагын цахим хуудсанд байршуулсан.<br>2022 онд тус хэлтэсээс нэг сул орон тоон дээр сонгон шалгаруулалтыг журмын дагуу зарлаж төрийн албаны нөөцөд байгаа иргэдээс нөхөн томилсон. Нийгмийн даатгалын төлөөлөгчийн орон тоонд байгууллагын цахим хуудас болон ХХҮГ-т зар хүргүүлэн нээлттэй байдлаар 1. Бичиг баримтын 2. Шалгалтын 3. Ярилцлагын гэсэн дараалаар сонгон шалгаруулж ажилласан. Сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд нээлттэй байдлаар байршуулсан.<br>НДХ-ийн дэргэдэх Сургалт, сурталчилгааны комисс, Ёс зүйн зөвлөл нь: Төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын үйлчилгээний соёл, Чанарын удирдлагын тогтолцоо сэдэвт сургалтыг зохион байгуулж нийт 35 албан хаагчийг хамруулсан. Мөн шинэ ажилтныг чадавхжуулах сургалт 3 удаагийн давтамжтайгаар зохион байгуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүй харилцаа, хандлагыг дээшлүүлэх тухай сургалтанд Нийгмийн даатгалын хэлтсийн 34 ажилтан албан хаагч 10 төлөөлөгч бүрэн хамрагдсан. Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөс зохион байгуулсан Төрийн байгууллагуудын дэргэдэх Ёс зүйн зөвлөлүүдийг идэвхижүүлэх, гишүүдийг чадавхижуулах зорилгоор Төрийн албан хаагчийн ёс зүйн үндэс, төрийн албаны үнэт зүйл, ёс зүйтэй шийдвэр гаргалт, нөлөөлөх хүчин зүйл сургалтанд НДХ-ийн дэргэдэх Ёс зүйн зөвлөлийн 4 гишүүн хамрагдсан байна.<br>Удирдлагын академын удирдлага сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч доктор профессор Г.Жаргалын Төрийн албан хаагчийн ур чадварын түвшин, ёс зүйн үзэл, ёс суртахууны төлөвшил сургалтанд тус хэлтсийн 26 байцаагч ажилтануудыг хамруулан ажиллалаа.<br><br>Нийгмийн даатгалын сан, хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны дунд хугацааны төсөөллийн санал боловсруулах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/1113 тоот албан бичгийг үндэслэн Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/16 дугаар тушаал гарган “Ажлын хэсэг” томилон, төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллав. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн дунджаар дүн шинжилгээ хийж 2023 оны төсвийн төсөл, 2024, 2025 оны төсөөллийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.<br>Сангийн санхүүгийн тайлан болон байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланг хагас, бүтэн жилээр хуулийн хугацаанд үнэн зөв хийж гүйцэтгэн сангийн яамны системд бүрэн гүйцэт байршуулан, тайлагнасан байна.<br>2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр “Зөлчилгүй” дүгнэлт авсан ба дүгнэлтээр өгсөн 1-Зөвлөмж, 3-Албан шаардлага, 1-Актыг биелэлтийг хуулийн хугацаанд гарган биелэлт, явцын тайлан баримтыг холбогдох байгууллагад хүргүүлэн Төрийн аудитын байгууллагын цахим системд оруулан ажилласан.<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль хэрэгжиж эхэлсэниэй холбоотойгоор Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/18 дугаар тушаалаар “нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, нийтлэх, шинэчлэх” үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж Ажлын хэсгийн ахлагчаар Хяналт, шалгалт дотоод аудитын тасгийн дарга Н.Бат-Эрдэнэ томилогдон ажиллаж нээлттэй мэдээллийн цахим хэлбэрээр байршуулах шинэчлэхэд хяналт тавин журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3. | Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай<br>2022.04.29 | УИХ-ын чуулганы 2022.04.29-ний өдрийн “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, ЗГ-ын 230 дугаар тушаалын дагуу Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журмыг хэрэгжүүлэн ажиллаж нөхцөл хангасан 44895 даатгуулагчдын 1 697,0 сая төгрөгийн буцаан олголтын мэдээлэлд дансны мэдээллийг бүртгэлжүүлэхэд банкуудтай хамтран ажиллаж илүү олгосон 15 даатгуулагчийн шимтгэлийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн аж ахуйн нэгж байгууллагын өр авлагын барагдуулан ажиллаж шимтгэлийн буцаан олголтыг олгох нөхцөлийг хангал ажиллаж байна. | | |
| *Монгол улсын хуулийн хэрэгжилтийн хувь 100%* | | | | |
| ***Хоёр. Ерөнхийлөгчийн зарлиг*** | | | | |
| 1 | Засгийн газарт чиглэл өгөх тухай<br>/Тэрбум мод/<br>2021-10-04<br>Дугаар 2021_58 | Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд Нийгмийн даатгалын хэлтэс нь нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн тоог нэмэгдүүлэх, түүний арчилгаа хамгаалалтыг сайжруулах, хэлтсийн ойр орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор шар хуайс, чацарга гэх мэт мод бут сөөгийг шинээр тарьж ургуулах шинээр хайс, хашлага барих сэлбэн засах ажиллуудыг хийж гүйцэтгээд байна. Мөн төрийн байгууллагуудын оролцоотойгоор Сархиа уулын энгэрт 2 удаагийн тарилтаар 80ш шинэс мод, мөн Баян-Өндөр уулын энгэр 40ш мод шинээр тарьж ургуулан | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 1.6. Аймаг, дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | тарьсан модоо эргэж тойрох арчлан хамгаалах албан хаагчийг томилон ажиллуулж байна.<br><br>2022 онд Нийгмийн даатгалын хэлтсийн “Залуучуудын холбоо”-ны жилийн ажлын төлөвлөгөөндөө тусгасан “нэг ажилтан 3 мод” хөтөлбөрийн хүрээнд нь хэлтсийн доторх ногоон байгууламжид шинээр чацарганы мод 10 ш, шар хуаис-20ш зэрэг мод шинээр тарьж ургуулан арчилгаа тордолгоог тогтмол хийж байна. Хэлтсийн хамаарал бүхий ногоон байгууламжийн хаалт, хашлагыг өөрсдийн нөөц бололцоогоороо сэргээн засварлаж ажилласан. Мөн Эрдэнэт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд НДХ-ийн хувиарт газартаа 30ш мод шинээр тарьж ургууллаа. | | |
| Ерөнхийлөгчийн зарлиг *хэрэгжилтийн 100 хувь* | | | | |
| ***Гурав. Засгийн газрын тогтоол*** | | | | |
| 1 | 2022.01.05 Дугаар 01<br>Журам шинэчлэн батлах тухай | Коронавируст халдвар /ковид-19/-ын тархалтын түвшинд үндэслэн хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан тус хэлтэс нь Халдвараас сэргийлэх дэглэм баримтлан ажиллах, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулахдаа дархлаа сэргээх нэмэлт тунд хамрагдсан, эсхүл түргэвчилсэн шинжилгээнд хамрагдаж сөрөг хариу гарсан ажилтан, иргэд даатгуулагчдыг оролцуулах, УОК-оос баталсан журмын дагуу байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тавигдах тусгай нөхцөл шаардлагыг мөрдөж ажиллахын зэрэгцээ, байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан халдвараас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн улиралд нэг удаа урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт хийлгэх, халдвар авсан хүнийг ажлын байранд ажиллуулахгүй байх, ажилтан, албан хаагчдыг дархлаажуулалтад хамруулах талаар уриалга гарган ажиллалаа.<br>Мөн ажилтан албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор “Монгол эм импекс ” ХХК-тай хамтран ажилтануудад 30% хүртэлх хөнгөлөлтэй үнээр Ковид-19 цар тахлаас урьдчлан сэргийлэх зорилгоор өндөр тунатай витамин C.D-г албан хаагчдад олгосны дээр хамгаалалтын маскаар ажилтан албан хаагчдыг ханган эрсдэлээс хамгаалаж ажиллаж байна.<br><br>*Хэрэгжилтийн 100%* | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | 2022.02.01 Дугаар 63<br>Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай | Монгол улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолын дагуу 16287 тэтгэвэр авагчид 2 тэрбум /сард/ төгрөгийн нэмэгдэл тооцож, 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдөр бүрэн олгосон. 2022 оны нэгдүгээр хагас жилд 10 тэрбум төгрөгийн тэтгэврийн нэмэгдлийг хуулийн хугацаанд олгосон. Тэтгэвэр авагч нараас ямар нэгэн гомдол гараагүй.<br>Дунд мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэж байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийн нэмэгдэл нь нөхөн даатгал хийгдсэн болон МУЗГ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор тэтгэврийн доод хэмжээ авч байсан тэтгэвэр авагчдын нэмэгдлээс бага хэмжээтэй байгаад сэтгэл дундуур байгаа тухай санал 13 тэтгэвэр авагчаас ирсэн.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | 2022.01.05 Дугаар 7<br>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай | Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь “Тод өнгө” ХХК-тай хамтран хэлтсийн төв хаалганы хаяг, тасаг , нэгжүүдийн хаалганы хаяг, үйлчилгээний заалны хаяг, архивын өрөө болон бусад өрөөний хаягийг 2017 оны А/173 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс (тасаг)-ийн ажлын байр үйлчилгээний орчны стандарт”-д заасны дагуу кирилл монгол бичгээр хослуулан бичиж байршуулж ажиллалаа. Цаашид, серверийн өрөөний хаяг, хурлын өрөөний хаягийг монгол бичгээр бичиж байрлуулах ажил хийгдэж байна. Тус хэлтсийн вэб хуудсыг бүрэн шинэчлэх ажил хийгдэж байгаа бөгөөд техникийн зарим нэг асуудлаас болж удаашралтай явагдаж байна. Нийгмийн даатгалтай холбоотой мэдээлэл сурталчилгааны самбар, гарын авлага, дотоод болон гадаад сургалтын хичээлүүдийг кирилл монгол бичгээр хослуулан хэрэглэж турших байна.<br><br>Нийгмийн даатгалын хэлтсийн даргын А/34 дүгээр тушаалаар ажилтан албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх хөтөлбөр батлан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>Хэлтсийн нийт 48 албан хаагчдаас эх хэлний анхан болон дунд шатны түвшин тогтоох шалгалт авч, сургалтын санал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж судалгаа авахад нийт албан хаагчдын 22 албан хаагч анхан шатны, 28 албан хаагч нь дунд шатны мэдлэгтэй гэж тодорхойлогдсон. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Сургалтын багц цагийг анхан болон дунд шат тус бүрээр 27 цаг байхаар төлөвлөж, 7 хоног бүрийн 5 дахь өдөр хичээллэж байна.<br>Мөн албан хаагчдын мэдлэгийг бататгах, сайжруулах зорилгоор Орхон аймгийн Номын төвтэй хамтран “Алтан хонх” тэмцээнийг албан хаагчдын дунд зохион байгуулж ажиллалаа.<br>Төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангах үүднээс тус хэлтсийн архив, бичиг хэргийн ажилтануудыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Орхон аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Архивын ерөнхий газраас зохион байгуулсан төрийн байгууллагын архив бичиг хэргийн ажилтнуудад үндэсний бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүй, албан хэргийг хос бичгээр үйлдэх стандарттай танилцуулах сургалтад 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр хамруулсны дээр тус хэлтсийн Монгол хэл үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад тогтмол хамрагдаж, төрийн албан хэргийг кирилл болон үндэсний бичгээр хөтлөн явуулах бэлтгэл ажлыг хангаН туршиж эхлээд байна.<br><br>*Хэрэгжилт 100%* | | |
| 4 | 2021.12.22 Дугаар 388<br>Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардал, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын болон туслах үйл ажиллагааны орлогын төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар БХСГ-02-2018” дагуу зардлыг ангиллыг мөрдөн батлагдсан төсвийн хүрээнд ажиллаж байна. Байгууллагын урсгал үйл ажиллагааны зардлыг Нийгмийн даатгалын ерөнхий газраас баталсан “ Үйл ажиллагааны зардлын 2022 оны төсвийн сарын хуваар”-ийн дагуу 9 төрлийн зардлын ангилал тус бүрээр зарцуулан ажилласан байна. Байгууллагын урсгал зардал жилээр 670.6 сая төгрөг хагас жилээр 347.2 сая төгрөг зарцуулахаар төлөвлөгөө батлагдаж 320.7 сая төгрөгийг зарцуулан ажилласан. Өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад үл нөлөөлөх урсгал зардлыг тэвчин хэмнэлтийн горимд шилжин ажилласан байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | 2021.12.14 Дугаар 374<br>Тогтоолын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай | Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 374 дүгээр тогтоолыг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох заалтуудыг хяналтандаа авч хавсралтуудын дагуу тайлан мэдээгээ Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлээд байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 6 | 2018.05. Дугаар 138<br>Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай | Тус хэлтсийн нийгмийн даатгалын ажилтнуудын ажлын компьютерт вирусийн эсрэг програмыг хэлтсийн бүх байцаагчдын компъютерт суулган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хэлтсийн байцаагч нарын ажлын компьютерийн интернэт, Flash, USB оролтыг хааж зөвхөн дотоод сүлжээгээр програм, мэдээ мэдээллийг солилцон ажиллаж байна. Улирал тутам програм, компьютерийн кодыг сольж төрийн мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Байцаагч тус бүрд өөрсдийн албаны мэйл нээж өгсөн, албан бичиг, баримтыг хувийн мэйлээр ашиглах байдлыг зогсоож, албан бичиг, баримтыг албаны мэйлээр авч ашиглан байцаагч нэг бүртэй төрийн болон албаны нууцын гэрээ байгуулж ажиллаж байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 7 | 2022.05.Дугаар 187<br>Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай | Иргэн хуулийн этгээдийн өргөдөл гомдлыг Call-center 75776699, мөн 70353511 дугаарын утсаар хүлээн авч тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна. 2022 оны байдлаар 2 өргөдөл хүсэлт ирсэнийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллалаа.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 8 | 2022.05.11 №192<br>Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай | Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай Засгийн газрын тогтоолын дагуу шинээр Төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдон ажиллаж байгаа албан хаагчийг томилон ажиллуулахдаа уг тогтоолын дагуу цалинжуулж байгаа бөгөөд ТҮ ангилал зэрэглэлд Засгийн газрын тогтоосон цалингийн доод хэмжээнээс доогуур цалинждаг байсан албан хаагчдыг шатлал ахиулан цалинжуулан ажилуулж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 9 | 2022.05.18 №201<br>Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журмын тухай | 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс НМИТБТухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус хэлтсийн 2022 оны 3 дугаар улиралын Сургалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” шинэчилсэн найруулга сэдвээр тус хэлтсийн Орлого шимтгэлийн байцаагч-Хуулийн зөвлөх Н.Хулан байцаагч ажилтануудад сургалт явуулж сургалтанд нийт 23 байцаагч ажилтан 8 төлөөлөгч хамрагдлаа.<br>Мөн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/18 дугаар тушаалаар нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулах, нийтлэх, шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж Ажлын хэсгийн ахлагчаар Хяналт, шалгалт дотоод аудитын тасгийн дарга Н.Бат-Эрдэнэ томилогдон ажиллаж нээлттэй мэдээллийн цахим хэлбэрээр байршуулах шинэчлэх хяналт тавих журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 10 | 2022.07.05 №266<br>Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрмийг шинэчлэн батлах тухай | Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэмд санал оруулах тухай тоотын дагуу зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдаанд саналын эрхгүй байх тухай санал хүргүүлж, хүргүүлсэн санал шинэ дүрэмд тусгагдаж ирсэн. 2022 оны байдлаар ГШЗөвлөл 5 удаа хуралдаж, 21 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 11 | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-05-25<br>Дугаар 2022_203 | 1. Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн дунджаар дүн шинжилгээ хийж 2023 оны төсвийн төсөл, 2024, 2025 оны төсөөллийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.<br><br>1.2. Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсөв нь 2022 онд 683.1 сая төгрөгөөр нийт 10 бүлэг зардлын төрлөөр батлагдан ирсэн ба өмнөх оны төсвөөс 2.8 хувиар буурсан байна. НДҮЗөвлөлөөс 2022 оны тодотгосон төсвөөр: | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | - Гэрэл цахилгааны зардал<br>- Түлш халаалтын зардал<br>- Цэвэр бохир усны зардал<br>- Бичиг хэргийн зардал<br>- Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал<br>- Тээвэр шатахууны зардал<br>- Урсгал засварын зардал г.м зардлуудыг бууруулан баталсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу хэмнэлтийн горимд шилжин ажиллаж байгаа боловч ихэнх зардлын бүлэг батлагдсан төсөвт хүрэлцэхгүй байгаа нь үнийн өсөлт бусад хүчин зүйлээс хамааралтай байна.<br>Тус хэлтэс 6 зардлын ангилалаар нийт 24.2 сая төгрөг нийт зардлын 3.5 хувийн хэмнэлт хийн ажилласан байна.<br>1.3. Тус хэлтсийн барилга нь 40 гаруй жил ашиглагдаж байгаа бөгөөд өмнө нь Цэцэрлэгийн зориулалтаар ашиглаж байсан загвар хийцтэй, дулааны шугам хоолойн элэгдэл гамшигийн түвшинд хүрсэн зайлшгүй шинэчлэх шаардлагатай байгаа боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу зарцуулалт хийгээгүй, зураг төсөв батлуулаагүй хөрөнгө оруулалтын зардал гаргуулаагүй ажилласаар байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 12 | Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай<br>2022-05-25<br>Дугаар 2022_204 | 1.1. Нийгмийн даатгалын сан, хэлтсийн үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2023 оны төсвийн төсөл, 2024-2025 оны дунд хугацааны төсөөллийн санал боловсруулах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 1/1113 тоот албан бичгийг үндэслэн Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/16 дугаар тушаал гарган “Ажлын хэсэг” томилон, хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.<br><br>1.2. НДЕГ-ын 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 06/1234 тоот албан бичгийн дагуу хэлтсийн суудлын авто машиныг зам тээврийн хөдөлгөөнд оруулахыг зогсоон албан хэрэгцээнд ашиглахаа больсон ба тус хугацаанаас хойш тээвэр шатахууны 412,300 төгрөгийн зардлыг хэмнэн ажилласан байна. Тус хугацаанд жолоочийг туслах ажилтнаар сэлгэн | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | ажиллуулж орлого, нийгмийн баталгааг байгаа түвшнээс бууруулахгүй байх арга хэмжээг авч ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 13 | Журам батлах тухай Дугаар 230 2022.06.08-ны өдөр Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх, тайлагнах, хяналт тавих журам | УИХ-ын чуулганы 2022.04.29-ний өдрийн “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, ЗГ-ын 230 дугаар тушаалын дагуу Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох журмыг хэрэгжүүлэн ажиллаж нөхцөл хангасан 44895 даатгуулагчдын 1 697,0 сая төгрөгийн буцаан олголтын мэдээлэлд дансны мэдээллийг бүртгэлжүүлэхэд банкуудтай хамтран ажиллаж илүү олгосон 15 даатгуулагчийн шимтгэлийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авч ажиллалаа. Аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн аж ахуйн нэгж байгууллагын өр авлагын барагдуулан ажиллаж шимтгэлийн буцаан олголтыг олгох нөхцөлийг хангаж ажиллаж байна. | | |
| *Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн дундаж: 100 хувь* | | | | |
| ***Дөрөв. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл*** | | | | |
| 1 | МУЗГ-ын 2022 оны 02 дугаар сарын 16-ны хуралдааны 11 дүгээр тэмдэглэл: | “Шинэ эргэлтийн бодлогод тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах, шинэчлэлийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох байгууллага албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны засаг дарга нар, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад даалгасан бөгөөд нийгмийн даатгалын хэлтэс нь Төрийн байгууллагын процессын дахин инженерчлэлийг тогтмол хийснээр байгууллагын дотоод процесс үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлага, шугаман 3 хяналтын цогц систем нэвтрэхээс гадна процессын үл тохирол, илүү хэрэггүй олон процесс дамжлагуудыг халсан. Мөн иргэний процесс, байгууллагын процессыг нарийн салгаж тодорхой болгосноор иргэн төвтэй процессыг нийгмийн | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | даатгалын байгууллагын бүх үйлчилгээнд нэвтрүүлж иргэн, даатгуулагч нийгмийн даатгалын бүхий л үйлчилгээг нэгээс илүү дамжлагагүйгээр нэг л төрийн албан хаагчаас нэг дор авах боломжийг бүрдүүлж иргэний процесс дамжлагыг 2-оос 7 дахин бууруулав.<br><br>Нийгмийн даатгалын хэлтэст 2 төрлийн Роботын процесс автоматжуулалт нэвтрүүлж нийгмийн даатгалын хэлтэст гараар хийдэг байсан Нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын гүйлгээг сангийн харилцах програмд бүртгэх ажлыг роботоор гүйцэтгүүлж байна. Мөн 13 ажилтан албан хаагчийн өдөр бүр олон давтамжтай хийдэг механик зарим бүтэн жилийн ажлыг роботоор 1.2 сарын дотор хийлгэх боломжийг бүрдүүллээ. RPA бол компьютер дээр дахин давтагдаж хийгддэг ажлыг, урьдчилан зааварласан дүрмийн дагуу гүйцэтгэдэг хиймэл оюун ухаанд суурилсан процессын автоматжуулалтын робот юм. RPA-р давтамж ихтэй, их нөөц зарцуулдаг, мэдлэг чадвар бага шаардсан ажлуудыг автоматжуулснаар төрийн албан хаагчид илүү үнэ цэнэтэй ажилд төвлөрөх боломжтой болж, байгууллагын бүтээмж, гүйцэтгэл их хэмжээгээр нэмэгдүүлсэн.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | МУЗГ-ын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 3 дугаар тэмдэглэл: | “Коронавирус халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 0-5 настай хүүхэдтэй эцэг эх гэрээсээ цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг бүх шатны төсвийн байгууллагын захирал дарга нарт даалгаж, хувийн хэвшлийн байгууллагын ажил олгогч нарт зөвлөсний дагуу Орхон аймгийн хэмжээнд томуу, томуу төст өвчний тархалт их байгаатай холбогдуулан 0-5 настай хүүхэдтэй эцэг эхчүүдийг гэрээс цахимаар ажиллуулах нөхцөлөөр хангах, ажлын цагийг уян хатан байдлаар зохицуулах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн хоёр албан хаагчийн бага насны хүүхдийн биеийн байдал хүндэрч эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх шаардлага үүссэн тул тухайн албан хаагчид цалинтай чөлөө олгох гэх мэт арга хэмжээ авч ажиллалаа. 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 4 албан хаагч гэрээс ажилласан байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | МУЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны 64 дүгээр тэмдэглэл: | Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь МУЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн хуралдааны 64 дүгээр тэмдэглэл болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газрын даргын 2022 оны | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 03 дугаар сарын 02-ны өдөр баталсан 7/419 тоот зөвлөмжийг үндэслэж Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан А/186 тоот хяналт шалгалтын нэгдсэн зааврын дагуу хэлтсийн даргаар 2022 оны 03 дугаар сарын 25-ны өдөр №4 дугаартай удирдамж батлуулж Орхон аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 105 аж ахуйн нэгж байгууллагуудад Нийгмийн даатгалд хамрагдсан байдал, шимтгэлийн тайлангаа үнэн зөв гаргаж байгаа зэргийг шалгаж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж зөвлөн туслах зорилгоор ажиллаж байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 4 | МУЗГ-ын 2022 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл: | 2022 онд тус хэлтэст Хөрөнгө оруулалтын зардал батлагдаж ирээгүй болно. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй болно.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 5 | МУЗГ-ын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэл: | Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн албан бичигт заасны дагуу албаны цахим шууданг зөвхөн албан хэрэгцээнд ашиглах, е-токен төхөөрөмжид тоон гарын үсгийг суулгахад зөвхөн албаны цахим шууданг ашиглахад зориулж нийт эрх бүхий 43 байцаагч, мэргэжилтнүүдийн албаны цахим шуудан(@ndaatgal.mn домэйн)-г идэвхжүүлэх, сэргээх, шинээр үүсгэх ажлуудыг хийж гүйцэтгэв.<br><br>Төрийн гэрчилгээжүүлэх байгууллага болох Үндэсний дата төв УТҮГ-т тоон гарын үсэг эзэмших эрх бүхий байцаагч, мэргэжилтнүүдийн албаны цахим шуудангийн талаарх холбогдох мэдээллийг хүргүүлсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан “Заавар батлах тухай” 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/130 тоот тушаалд заасан “Е-токен төхөөрөмж ашиглах заавар”-ыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст ажиллаж буй тоон гарын үсэг эзэмших эрх бүхий нийт байцаагч, мэргэжилтнүүдэд мөрдүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Хэлтсийн мэдээллийн технологийн мэргэжилтнээр тоон гарын үсэг эзэмших эрх бүхий байцаагч, мэргэжилтнүүдийн албан компьютерт тоон гарын үсгийн esign-client-program-ийг суулгаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын “Бүртгэлийн нэгж”-ээс ирэх тоон гарын үсгийн е-токен төхөөрөмж шууд ажиллахаар тохируулан бэлэн байдалд оруулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын ерөнхий газарт тоон гарын үсгийн өргөдлийг шийдвэрлэх, мэдээллийг дахин магадлан шийдвэрлэх, татгалзах, зөвлөгөө өгөх, мөн “Бүртгэлийн ажилтан”-уудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах эрх бүхий тусгайлсан “Бүртгэлийн нэгж”-ийг зохион байгуулсан. Бүртгэлийн нэгжтэй шууд харилцах, тоон гарын үсэг эзэмших тухай өргөдлийг хүлээн авах, бүртгэх, мэдээллийг шалган шийдвэрлэх, татгалзах, зөвлөгөө өгөх, эрх бүхий анхан шатны “Бүртгэлийн ажилтан”-ыг томилсон. Мөн бүртгэлийн ажилтан нь нийгмийн даатгалын хэлтэст ажиллаж буй албаны тоон гарын үсэг эзэмших эрх бүхий 43 албан тушаалтан (Нийгмийн даатгалын “CORE” багц систем болон түүнтэй уялдаж ажиллах эрх бүхий байцаагч, мэргэжилтэн)-ий мэдээллийг гаргаж, Үндэсний дата төв УТҮГ-ын бүртгэлийн esign.gov.mn сайтад оруулж баталгаажуулсан.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 6 | 2018.05.30. №23<br>“Иргэд олон нийттэй харилцах төв” болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд хуулийн хугацаанд хариу өгч, иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх | Тус хэлтэст 2022 оны байдлаар 349 өргөдөл ирсэний 42 тэтгэвэр, 42 тэтгэмж тогтоолгох өргөдөл, бусад 263 өргөдөл ирсэнийг бүртгэлд авч хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэж НДЕГ, аймгийн ЗДТГ-т шийдвэрлэлтийн мэдээг улирал тутам хүргүүлж ажиллаа.<br>Агуулгаар нь авч үзвэл:<br>1. Тэтгэвэртэй холбоотой асуудлаар нийт- 42<br>Өндөр насны тэтгэвэр -30<br>Тахир дутуугийн тэтгэвэр -9<br>Тэжээгчээ алдсаны тэтгэвэр -3<br>2. Тэтгэмжтэй холбоотой асуудлаар -42<br>Хөдөлмөрийн чадвар түр алдсан тэтгэмж -25<br>Жирэмсэн амаржсаны тэтгэмж -11<br>Оршуулгын тэтгэмж -0<br>Ажилгүйдлийн тэтгэмж -6 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | 3. Бусад асуудлаар буюу нийгмийн даатгалын шимтгэлийн залруулга хийлгэх, регистрийн дугаар нэгтгүүлэх, илүү төлсөн мөнгө буцаан авах болон хэлтсийн албан хаагчдаас ирүүлсэн 263 өргөдөл байна<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 7 | 2022.8.17-ны өдрийн МУЗГ-ын 41-р тэмдэглэл | Удирдлага, зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт, арга хэмжээ мөн Санхүү, хөрөнгийн эх үүсвэрээс шатгаалан эхлээгүй байгаа төсөл тус хэлтэст байхгүй болно.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 8 | 2022.09.22-ны өдрийн 46 дугаар тэмдэглэл | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийг батлагдан гарсан тухай бүр төрийн албан хаагчдад сургалтаар мэдээллийг хүргэн ажиллаж дотоод сүлжээнд байршуулан ажиллаж байна. Мөн иргэд даатгуулагчдад хууль тогтоомжийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж байгууллагын вэб хуудас, фэйсбүүк хуудсаараа дамжуулан иргэдэд ойлгомжтой энгийн фостер байдлаар бэлтгэн хүргэж байна. Мөн өдөр тутам лайв буюу шууд нэвтрүүлгээр иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч, хуулийг сурталчлан ажиллаж байна. Хэрэгжилт удаарширалтай, гүйцэтгэл хангалтгүй байгаа шийдвэр, төсөл, арга хэмжээ, үүрэг, даалгавар тус хэлтэст байхгүй болно. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэн зөв тайлагнаж дээд шатны байгууллагыг хүргүүлэн ажиллаж байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Засгийн газрын хуралдааны хэрэгжилтийн дундаж: хувь 100%* | | | | |
| ***Тав. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол*** | | | | |
| 1. | 2021.12.27 Дугаар 20<br>“Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл тогтоох тухай” | Тэтгэврийн дансны нэрийн дансны тухай хуулийн дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэлийг 2022-2024 онд эмэгтэй даатгуулагчид 22 жил, эрэгтэй даатгуулагчид 15 жилээр тус тус тогтоосон тухай НДҮЗ-ийн 20 дугаарын тогтоолыг хэлтсийн байцаагч ажилтнуудад дотоод сургалтын зарт дээр мэдээлэл хүргэж ажиллав.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2. | 2021.12.27 Дугаар 21 тогтоол "Нэрийн дансны 2021 оны орлогод тооцох хүүгийн хэмжээ тогтоох тухай" | Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2021 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээ 11.6 хувиар баталсан НДҮЗ-ийн 21 дүгээр тогтоолын мэдээллийг дотоод сургалтын цагаар хэлтсийн байцаагч, ажилтнуудад хүргэж, шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагууд, иргэд даатгуулагч нарт хийсэн сургалтын үеэр мэдээллийг хүргэж ажиллав. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | 2022.08.01 №04 Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хэлтсийн байцаагч ажилтнуудад танилцуулж, иргэд даатгуулагч нарт 2023 оны 01- дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан оршуулгын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг хоёр сая төгрөг /2 000 000/-өөр тооцон олгох тухай мэдээллийг тухай бүр хүргэн ажиллаж байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолыг хэрэгжилтийн дундаж: 100%* | | | | |
| ***Зургаа. Ерөнхий сайдын албан даалгавар*** | | | | |
| | 2022.03.04 №03 Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай | Цахим тоон гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг тоон гарын үсгээр тайлагнах ажлыг эрчимжүүлэн ажиллаж 1405 аж ахуйн нэгж байгууллагад сургалт мэдээллийг хүргэж Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн пэйж, вэб хуудсаар дамжуулан 4 удаагийн лайв хийж, өмнөх онд 116 аж ахуйн нэгж тайлагнадаг байсан бол энэ онд 755 аж ахуйн нэгж байгууллага тайлан ирүүлж 6,5 дахин өссөн байна.<br>Цахимаар иргэдэд мэдээлэл хүргэх ажлын хүрээнд энэ онд 42 удаагийн шууд бичлэг 116 шинэ постер бэлтгэснийг давхардсан тоогоор 17.6 сая хүн үзсэн хандалттай байна. Мөн цахим хуудасны чатаар иргэдэд мэдээлэл өгөх үйлчилгээ үзүүлэн ажилладаг бөгөөд энэ онд 400 иргэний | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | материалийг цахим хуудсаар хүлээн авч шийдвэрлэсэн байна. Мөн нийгмийн даатгалын хэлтэс нь Үндсэн болон тэтгэврийн архиваа бүрэн цахимжуулаад байна.<br>Тэтгэвэр тогтоолтын хуудсыг цахимжуулж emongolia төрийн мэдээллийн цахим системд оруулах тухай хүсэлтийг 2022 оны 06 дугаар сард НДЕГ болон ХНХЯ- хүргүүлснээр иргэд цахимаар мэдээллээ авдаг болж, хэлтэст 0.6 сая төгрөгийн цаасны хэмнэлт гарч иргэдийн тодорхойлолт авахад 20 минут зарцуулдаг байсан цагийг 90 хүртэлх хувиар бууруулсан байна.<br>Нийгмийн даатгалын хэлтэст Роботын процесс автоматжуулалт нэвтрүүлж нийгмийн даатгалын хэлтэст гараар хийдэг байсан даатгалын сангийн орлого зарлагын гүйлгээг сангийн харилцах програмд бүртгэх ажлыг роботоор гүйцэтгүүлж байна. Мөн 13 ажилтан албан хаагчийн өдөр бүр олон давтамжтай хийдэг механик /бүтэн жилийн/ ажлыг роботоор 1.2 сарын дотор хийлгэх боломжийг бүрдүүллээ. RPA бол компьютер дээр дахин давтагдаж хийгддэг ажлыг, урьдчилан зааварласан дүрмийн дагуу гүйцэтгэдэг хиймэл оюун ухаанд суурилсан процессын автоматжуулалтын робот юм. RPA-р давтамж ихтэй, их нөөц зарцуулдаг, мэдлэг чадвар бага шаардсан ажлуудыг автоматжуулснаар төрийн албан хаагчид илүү үнэ цэнэтэй ажилд төвлөрөх боломжтой болж, байгууллагын бүтээмж, гүйцэтгэл их хэмжээгээр нэмэгдүүллээ.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийн дундаж: 100%* | | | | |
| ***Долоо . Сайдын тушаал*** | | | | |
| 1 | 2022.01.24 A/11<br>“Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх тухай” | Мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоог хөгжүүлэх асуудал Боловсрол шинжлэх ухааны яаманд шилжсэнтэй холбоотойгоор Орхон аймаг дахь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг шилжүүлэхэд хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд туслах, ажил хүлээлцэхэд оролцож дэмжлэг үзүүлэн ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | 2021.11.15 A/03<br>“Салбарын бодлого, төсвийн уялдааг хангах ажлыг зохион байгуулах тухай” | Нийгмийн даатгалын сангийн орлогыг жигд ханган биелүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь иргэд даатгуулагчдад | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хүртээмжтэй түргэн шуурхай олгох, урт хугацаат өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулан ажилласан ба 2022 оны байдлаар: Сангийн орлого 137.1 тэрбум буюу 96.4 хувийн биелэлтэй Сангийн зарлага 137.3 тэрбум буюу 98.8 хувийн биелэлттэй байна.<br><br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | 2021.12.06 А/191<br>Журам батлах тухай<br>“Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам” | Тус хэлтэс нь ээлжийн амралтыг тооцож олгохдоо ХНХ-ын Сайдын 2021 оны А/191 тоот тушаалаар баталсан журмын дагуу ээлжийн амралтыг тооцож олгож байна. Журамд заасан 3 арга хэмжээний 27 заалтыг үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 99 дүгээр заалтад заасан ээлжийн амралтын үндсэн хоног болон нэмэгдэл амралт, мөн ээлжийн амралтын цалинг тухайн ажлын жилийн дундаж цалин хөлснөөс тооцож олгож байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 4 | 2020.05.08№А/121<br>Ажилтныг тэтгэвэрт бэлтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөний жишиг загвар батлах тухай | Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр”-иин хүрээнд 2022 онд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022 онд өндөр насны тэтгэвэрт гарч байгааа албан хаагч тус хэлтсээс байхгүй байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 5 | 2020.12.30<br>№ 246, А/245<br>“Маягт, журам батлах тухай | Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/246 , Сангийн сайд хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны хамтарсан 246/А/245 тоот тус тушаалаар батлагдсан, нийгмийн даатгалын сангийн программ хангамжид орсон З-НД, Б-НД маягтуудыг 2021 оноос эхлэн хөтөлж ажиллаа. Уг ажлын хүрээнд ”Нийгмийн даатгалын сангийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх журам”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Орхон аймагт үйлчилгээ явуулж байгаа ажил олгогчдод нийгмийн даатгалын цахим үйлчилгээ, НДСангийн анхан шатны баримт, маягтын талаар мэдлэг ойлголтыг өгч, нийгмийн даатгалын цахим дэвтрийн бүрдэл үнэн зөв бүрэн хангагдсанд мэдлэг ойлголттой болсноор даатгуулагч өөрөө хяналт тавьдаг болсон.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *Сайдын тушаалын хэрэгжилтийн дундаж: 100%* | | | | |
| ***Найм. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал*** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 1 | 2022.01.03 А/01<br>2022 оны “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80 жил” болгон зарлах тухай | “Эрх зүй, мэдээллийн технологийн шинэчлэл-80” жилийн хүрээнд Нийгмийн даатгалын хэлтэс нь 3 зорилт 12 арга хэмжээ төлөвлөн ажиллаж жилийн тайланг НДЕГ-т хүргүүлж ажилласан. Мөн зорилтод жилийн хүрээнд шинээр 4 ажил төлөвлөн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 2 | 2022.02.01 А/17<br>“Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар батлах тухай” | МУЗГ-ын 2022 оны 63 дугаар тогтоол, НДЕГ-ын даргын 2022 оны А/17 дугаар тушаалаар баталсан зааврыг тус тус үндэслэн Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын А/09 дугаар “Тэтгэврийн нэмэгдлийг тэтгэврийн хувийн хэрэгт бичих, тэтгэврийн олголтыг шалгах тухай” тушаалаар батлагдсан ажлын хэсэг 22 улсын байцаагч, 4 төлөөлөгч нарын бүрэлдэхүүнтэй томилогдож тэтгэврийн хувийн хэрэгт засгийн газрын нэмэгдлийн дүнг бүрэн бичиж, тэтгэврийн олголтыг шалгасан. Ямар нэгэн зөрчил дутагдал илрээгүй. Тэтгэврийн хөдөлгөөнт архиваас татах тэтгэврийн эрхийн харилцаа дуусгавар болсон 17 хувийн хэргийн татаж, тэтгэврийн олголт, хөдөлгөөн хариуцсан байцаагч Ж. Уянгад хүлээлгэн өгсөн.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 3 | 2022.02.22 А/22<br>“Тушаал хүчингүй болгох тухай”<br>Нийгмийн даатгалын лавлагаа үнэ төлбөргүй болгох тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/22 тоот тушаалын дагуу маягт болон үйлчилгээний орлогын харилцах дансыг 2 дугаар сарын 28 өдрөөс хааж лавлагааг үнэ төлбөргүй болгон тус хугацааг хүртэл төвлөрсөн 54985.06 төгрөгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв санд бүрэн төвлөрүүлж ажиллав.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 4 | 2022.02.24 А/31<br>“Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам” батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2022 оны А/31 тушаалаар батлагдсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”-ын талаарх сургалтыг байцаагч ажилтнуудад хийж, тэтгэврийн баримт материал хүлээн авахдаа мөрдөж ажиллаж байна. 2022 оны нэгдүгээр хагас жилд 1515 тэтгэвэр шинээр тогтоосон.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 5 | 2022.03.29 А/55<br>Туслах малчин гэрийн үйлчилгээний ажилтан тэдгээртэй адилтгах ажилтантай | Хүнс хөдөө аж ахуйн газартай хамтран Баян-Өндөр сумын Малчин багийн иргэдэд зөвлөгөө мэдээлэл хүргэхээр 9 чиглэлд ажиллаж 358 | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | байгуулах хөдөлмөрийн гэрээний загвар батлах тухай | өрхийн 479 малчинд зөвлөгөө мэдээлэл хүргэн ажилласан. Мөн малчин багийн засаг дарга н.Баянзултай хамтран 57 иргэнд малчны тэтгэврийн мэдээлэл, Жаргалант сумын малчин газар тариалан эрхлэгчдийн зөвлөгөөнд оролцсон 170 иргэнд нийгмийн даатгалын тухай хууль болон сайн дурын даатгалын тухай мэдээлэл хүргэж ажилласан. Хөдөлмөрийн гэрээ бүхий туслах малчны судалгааг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс болон Баян Өндөр сумын ЗДТГ-т гаргуулан авч одоогоор бүртгэгдээгүй байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 6 | 2022.04.27 А/72<br>Журам батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/72 дугаар Журам батлах тухай тушаалын дагуу 2022 оны 01 дүгээр сараас хойш Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авахаар хүсэлт гаргасан 12256 даатгуулагчид нийт 2.406.488.508 төгрөгийн тэтгэмж , жирэмсэн болон амаржсаны тэтгэмж авахаар хүсэлтээ гаргасан 1641 даатгуулагч эхэд нийт 3.341.825.315 төгрөгийн тэтгэмжийг тус тус тооцож олгосон байна. Эрүүл мэндийн байгууллагаас илгээсэн эмнэлгийн хуудаснаас эрх үүсээгүй 36 эмнэлгийн хуудсыг тэтгэмжийн байцаагч, хугацаа хоцроож бичсэн 29 эмнэлгийн хуудсыг магадлагч эмч буцаасан байна.<br><br>Эрүүл мэндийн байгууллагаас нийт 214 эмнэлгийн хуудсыг хүчингүй болгосон байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 7 | 2022.05.25 А/87<br>“Эд хөрөнгийн улсын үзлэг тооллого явуулах тухай” | НДЕГ-ын даргын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн А/87 тоот албан бичгийн дагуу “Эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого явуулах тухай” ажлын хэсгийг байгууллан хэлтсийн санхүүгийн тайланд бүртгэлтэй 7 төрлийн /Барилга байгууламж, Нийтийн эзэмшлийн тохижолт, Авто | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | тээврийн хэрэгсэл, МТТ, ТЭХ, Биет бус хөрөнгө..../ 634.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолж, элэгдэл хорогдол, ашиглалтын хугацаа зэргийг хянан баталгаажуулж Төрийн өмчийн бодолго зохицуулалтыг газраас гаргасан нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 8 | 2022.03.25 А/53<br>Аймаг дүүргүүдэд зохион байгуулах сургалтын төсвийн хуваарь батлах тухай | Нийгмийн даатгалын хэлтсийн даргын тушаалаар Сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг томилж ҮОМШӨ-өөс урьдчлан сэргийх сонгон шалгаруулалтанд 2 байгууллага материалаа ирүүлснээс “Нийгмийн эрүүл мэндийн даатгалын үндэсний нийгэмлэг” ТББ шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. Сургалт хийсэн тухай дэлгэрэнгүй тайлан мэдээг болон санхүүгийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 9 | 2022.06.15 А/99<br>Заавар батлах тухай | Нийгмийн даатгалын шимтгэлийг буцаан олгох, бүртгэх тайлагнах, хяналт тавихад баримтлах журмыг хэрэгжүүлэх зааварын дагуу бүртгэлтэй 1405 аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд нь хүлээн авч судалгаа гаргаж, 1000000 төгрөгөөс доош цалинтай иргэдийн банкны дансны мэдээллийг сар бүр шинэчлэн засварлаж, өр авлага үүсгэсэн аж ахуйн нэгж байгууллагын өр авлагыг барагдуулан ажиллаж байна.<br>Албан журмын даатгуулагч- 20202<br>Сайн дурын даатгуулагч эх- 1625<br>Сайн дурын даатгуулагч- 4599<br>Даатгуулагчийн буцаан олголтыг олгох нөхцлийг ханган ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 10 | 2022.06.10 А/98 Заавар батлах тухай | Нийгмийн даатгалын сангийн төсвийн төсөл, төсөөлөл боловсруулахад баримтлах заавар, Үйл ажиллагааны урсгал зардал хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний зардлын болон туслах үйл ажиллагааны орлогын төсвийн төсөл төсөөлөл боловсруулахад | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | баримтлах заавар”-ын дагуу Нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг сүүлийн 5 жилийн дунджаар дүн шинжилгээ хийж 2023 оны төсвийн төсөл, 2024, 2025 оны төсөөллийг хуулийн хугацаанд хийж гүйцэтгэн дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 11 | 2022.05.31 А/94 Аудитын зөвлөмж хэрэгжүүлэх тухай | 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр “Зөлчилгүй” дүгнэлт авсан ба дүгнэлтээр өгсөн 1-Зөвлөмж, 3-Албан шаардлага, 1-Актыг биелэлтийг хуулийн хугацаанд гарган биелэлт, явцын тайлан баримтыг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.<br>Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон сангийн нягтлан бодох бүртгэлд ашиглах бодлогын баримт бичиг нь 2018 оноос хойш шинэчлэгдээгүй ба ажилтан албан хаагч мөрдөн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 12 | 2022.07.05 А/109 Даатгуулагчийн төрлийн код шинээр батлах тухай | 1. Хүүхдээ асрах чөлөөтэй хугацаанд ажил олгогчоос хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлого олгосон эцэг эхийг бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг “68”,<br>2. Цэргийн алба хаасны болон ХЧА-ны тэтгэвэр тогтоолгосон боловч ажил хөдөлмөр эрхэлж байгаа цэргийн албан хаагчийн бүртгэх даатгуулагчийн төрлийн кодыг “69” гэж тогтоон ЗХ-ний 186-р анги, ЗХ-ний 110-р анги болон Цагдаагийн газар, Онцгой байдлыг газарт мэдээлэл хүргүүлэн зөвлөмж өгч тус төрлийг хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 13 | 2022.10.03 А/145 Нийгмийн даатгалын салбарын хүүхэд хамгааллын бодлого батлах тухай | Нийгмийн даатгалын салбарын хүүхэд хамгааллын бодлого батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл НДХ-ийн хүүхэд хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлэн бага насны хүүхэдтэй эцэг эхчүүдийн ажлын цагийн уян хатан байдлыг баримтлан ажиллаж байна. Орхон аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас 2022 оны 03 дугаар сард хамтран ажиллах ажлын хүрээнд хүүхдийг орчны осол гэмтэлд өртөхөөс сэргийлэх чиглэлээр “ НЭГДҮГЭЭРТ ХҮҮХЭД, НЭГДҮГЭЭРТ ШАЛГА “ арга хэмжээний хүрээнд албан хаагчдын хүүхдийн цэцэрлэг сургуулийн орчны эрсдлийг бууруулах хүрээнд шалгах, мэдээллэх, орчныг ээлтэй болгоход чиглэн санал асуулгад хамруулан ажиллав. Мөн “Бүх хайраа гэр бүлдээ” сарын аяны хүрээнд аймгийн ЗДТГ болон ГБХЗХГ-аас зохион байгуулсан “ Гэр бүлийн чуулган” –д албан хаагчийн 2 гэр бүлийг | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | оролцуулсан. "ХҮҮХЭД ХҮМҮҮЖҮҮЛЭХ ЭЕРЭГ АРГА" сургагч багш бэлтгэх сургалтанд байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 2 гишүүн хамрагдаж байгууллагынхаа эцэг эхчүүдэд сургалт мэдээлэл хүргэж хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэн ажиллаж байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 14 | 2022.06.22 № А/64 Нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны болон сангийн нягтлан бодох бүртгэлд ашиглах бодлогын баримт бичиг нь 2018 оноос хойш шинэчлэгдээгүй ба ажилтан албан хаагч мөрдөн ажиллаж байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 15 | 2022.08.25№ А/121 Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлэх, цочрол хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх зорилтод төсөл хэрэгжих тухай | Малчдыг нийгмийн даатгалд хамруулах ажлын хүрээнд Баян-Өндөр, Жаргалант сумын малчдаар 2 дугаар сар болон 10 дугаар сард 2 удаа 18 чиглэл байцаагч төлөөлөгч ажиллаж 724 /давхардсан тоогоор/ малчин иргэнд нийгмийн даатгалын даатгалын зөвлөгөө үйлчилгээ хүргэн ажилласан. 03 дугаар сарын 10-ны өдөр малчин багийн 57 иргэнд, 04 дүгээр сарын 19-нд "Малчин тариалагчдын зөвлөгөөн"-нд 175 малчин тариаланч иргэдэд тус тус малчны эрүүл мэнд сайн дурын даатгалын тухай мэдээллийг малчдад хүргэн ажиллалаа. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 16 | 2022.09.02 № А/132 ГШЗ-Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | МУЗГ-ын 2022 оны 266 дугаар тогтоолын хавсралтын дагуух Гомдлын шаардлагын дүрэмд үндэслэн хэлтсийн дэргэдэх ГШЗ-ийн бүрэлдэхүүний саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт, шалгалтын газарт хүргүүлж, бүтцийг батлуулан ажиллаж байна. *Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 17 | 2022.10.12 № А/152 80 жил 8 бүтээлч ажил аян зохион байгуулах тухай | Нийгмийн даатгалын байгууллага үүсч хөгжсөний 80 жилийн ойн хүрээнд хэрэгжүүлэх 80 жил 8 бүтээлч ажлын аяныг эхлүүлэн албан хаагчдын ажлын ачаалал, иргэдэд үйлчилгээ узуулж байгаа арга хэлбэрийг хялбаршуулах програм хангамжийг бий болгох цахимжуулах зорилгоор Роботын процесс автоматжуулалт, нийгмийн даатгалын байгууллагын процессийн дахин инженерчлэл, Карте буртгэлийн систем, Цахим архив, Ухаалаг архив, сап center уйлчилгээ, чат бот уйлчилгээ, гуйцэтгэлийн удирдлагын live dashboard систем зэргийг хегжүүлэн уйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Ажлын байрнаас уудэлтэй стресс зохицуулж сурах нь" сэдэвт сургалтанд 25 ажилтан хамрагдлаа.<br>Спорт арга хэмжээг зохион байгуулан сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар гэсэн гурван төрлөөр 2022 оны 10 сарын 29-нд зохион байгуулж шилдэгуудээ тодрууллаа.<br>"Харилцаа, хандлагаа дээшлүүлэх тухай" доктор А.Нармандах багшийг урьж сургалт зохион байгуулан Солонгос улсад зүрхний хагалгаанд орж буй Эрдэнэт хотын охин Г. Номууны эмчилгээнд хамт олноо уриалан хандив тусламж үзүүллээ.<br>Цахим уйлчилгээг сайжруулж Facebook хуудсаар дамжуулан Нийгмийн даатгалын хууль эрх зуйн 12 постер бэлдэн 35 752 /давхардсан тоогоор/ иргэнд мэдээлэл түгээн ажилласан байна.<br>Орхон аймгийн төрийн байгууллагын процессын дахин инженерчлэл, ухаалаг архив, цахим архив, ухаалаг ногоон ажлын байр зэрэг төсөл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн 284 байгууллагад тэргүүн туршлагаа хуваалцсан байна. Мөн түүнчлэн Засгийн газрын Шинэ сэргэлтийн бодлогын хурдасгуур төвийн Систем хөгжүүлэлтийн хэлтсийн дарга Г.Ганбат, Ногоон бутээмж хөгжлийн бодлогын газрын дарга С.Санчир нарт иржтуршлага солилцож ажиллалаа. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Бутээмжийн өсөл ба инноваци дахь бух нийтийн оролцоо" чуулганд оролцож 60 гаруй байгууллагад туршлага судлууллаа.<br>Орхон аймгийн Байгаль, орчны газартай хамтран ажиллаж Сарха уулын энгэрт 80 ширхэг шинэс мод шинээр тарьж ургуулан өөрсдийн байгууллагын таних тэмдэгжүүлэн арчлалт хамгаалалтад анхааран хариуцан ажиллаж байна. Мөн Эрдэнэт Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд 30 ширхэг шар хуайс мод тариж ургуулаад байна.<br><br>2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 1766 тоотоор 80 жил 80 бүтээлч ажлын тайланг гаргаж хүргүүлсэн болно.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 18 | 2022.10.25№ А/161<br>Журам хүчингүй болгох тогтоол хэрэгжүүлэх тухай | "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын дагуу тус хэлтсийн "Өмч хамгаалах байнгын зөвлөл" нь 2022 онд үндсэн хөрөнгийн тооллогыг 3 удаа зохион байгуулсан ба ТӨБЗГазраас хийсэн 2022 оны Улсын үзлэг тооллогод хамрагдан 94% биелэлтэйгээр гэрээг дүгнүүлсэн байна. Мөн байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайланд шинэ систем | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | нэвтэрч байгаатай уялдуулан жилийн эцсийн тооллогыг шинэ системээр хийж гүйцэтгэсэн байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 19 | 2022.10.14 А/155 Журам батлах тухай | Орхон аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн цахим хуудсыг НДЕГ-ын даргын баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын фэйсбүүк хуудас ашиглах” журмын дагуу хөтлөн явуулж байна. Цахим хуудсыг даган мэдээлэл авдаг 17 мянган хэрэглэгч, чатаар мэдээлэл авдаг 6 мянга орчим хэрэглэгч, цахимаар 400 иргэнээс материал хүлээн авч шийдвэрлэсэн байна. Мөн цахим хуудсанд долоо хоног бүр шинэ постер бэлтгэх, 7 хоногт 3-5 удаа шууд бичлэгээр иргэдэд мэдээлэл хүргэх, богино хэмжээний бичлэг бэлтгэн мэдээлэл түгээх зэрэг ажлыуулыг тогтмол хийж хэвшсэн болно. Постерыг крилл үсгээр бэлтгэж цахим хуудсанд байршуулсан мэдээллээ журамд зааснаар төрөлжүүлэн альбом үүсгэж цахим хэрэглэгч мэдээлэл авахад хялбар болгосон болно.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 20 | А/157 Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай | Булган аймагт зохион байгуулагдсан Улсын байцаагчийн эрх олгох, эрх сэргээх, эрх баталгаажуулах шалгалтад тус хэлтсээс 2 байцаагч шинээр эрх авч, 2 байцаагч эрх сэргээж 15 байцаагч эрх баталгаажуулж 100% амжилттай оролцсон болно.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| 21 | А/151 Журамд өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын зөвлөл, НДХ-ийн дарга нартай хамтарсан “Цахим хуралдаан зохион байгуулах журам”-д орсон өөрчлөлтийг мөрдөн ажиллаж байна.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *НДЕГ-ын даргын тушаалын дундаж: 100%* | | | | |
| ***Ес. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан даалгавар*** | | | | |
| 1 | 2022.01.25 Дугаар 01 | Авилга гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ажилтан албан хаагчдыг соён гэгээрүүлэх үүднээс Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, нийгмийн даатгалын байгууллагын дүрэм, нийгмийн даатгалын байцаагчийн дүрмийг нийт ажилтан албан хаагчдад сурталчилан таниулж, судлуулан Цагдаагийн хэлтсээс сургалт авч, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан авилга, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай 2 удаагийн /2022 оны 2 дугаар сарын 22, 23- | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | “Ёс зүй сахилга хариуцлагын дээшлүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” | ны өдрийн/ цахим сургалтанд төрийн захиргааны албан хаагчдыг хамруулж,<br>Хэлтсийн ёс зүйн зөвлөл нь хандлага, ёс зүйн талаарх сургалтыг жилийн туршид хуваарийн дотоодын сургалтын төлөвлөгөөнд оруулан ажиллаж байна. 2022 онд 1-р улиралд нийт байцаагч ажилтаны ёс зүй, сахилга батыг сайжруулах талаар<br>➢ 2022-02-23нд Авилгатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлига, түүний шалтгаан, нөхцөл, үр дагавар, авлигаас урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтанд нийт 19 ажилтан хамрагдсан.<br>➢ 2022-03-10нд нийслэлийн Прокурорын газар НДЕГ-тай хамтран зохион байгуулсан “Зөрчлийн тухай хууль” сэдэвт сургалтанд хяналт болон орлого шимтгэлийн тасгийн 8 байцаагч хамрагдсан.<br>➢ 2022-03-03нд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Манлайлал хэв маяг, хандлага тодорхойлох нь” сэдэвт сургалтанд нийт 9 ажилтан цахимаар хамрагдсан.<br>➢ 2022-03-13нд Цагдаагийн газраас зохион байгуулсан “Зөвийг зөвлөе” сэдэвт сургалтанд нийт 14 ажилтан хамрагдсан байна.<br>Байцаагч ажилтнуудыг хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхээс урьдчилан сэргийлж, хариуцлагын гэрээг байгуулж, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллүүдийг ёс зүйн зөвлөлөөс зохин байгуулж ажиллаж байна. 2022 оны 1 дүгээр улиралд 2022.02.10-ны өдөр иргэн үйлчлүүлэгчээс ирсэн гомдлын дагуу ёс зүйн зөвлөл хуралдаж нэг цонхны үйлчилгээний байцаагч С нь ёс зүйн зөрчил гаргаагүй харин ажлын цаг ашиглалтанд анхаарах талаар сануулга өгсөн.<br>Төрийн албаны зөвлөлийн долоо хоног бүрийн пүрэв гарагт зохион байгуулдаг цахим сургалтуудад байцаагч ажилтнуудаа хамруулж байна.<br>Мөн улирал бүрийн 25-ны өдрийн дотор албан даалгаврын биелэлтийг НДЕГ-т хүргүүлэн ажилласан. 4 дүгээр улиралын тайланг 12 дугаар сарын 02-ны өдөр 1847 албан тоотоор НДЕГ-т хүргүүлж ажиллалаа.<br>*Хэрэгжилтийн хувь 100%* | | |
| *НДЕГ-ын даргын албан даалгаврын хэрэгжилтийн дундаж: 100 хувь* | | | | |
| *Нийт дундаж: 100%* | | | | |

Биелэлтийн товчоо

| Д/д | Зорилт арга хэмжээ | Арга хэмжээний тоо | Үнээс | | | | Хэрэгжилтийн тооцох хугацаа болоогүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% биелсэн | Хэрэгжих шатандаа | | | | |
| | | | | 70% | 30% | 0% | | |
| 1 | Монгол Улсын хууль | 3 | 3 | | | | | 100% |
| 2 | Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | 1 | | | | | 100% |
| 3 | Засгийн газрын тогтоол | 13 | 13 | | | | | 100% |
| 4 | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | 8 | 8 | | | | | 100% |
| 5 | НД-ын ҮЗ-ын тогтоол | 3 | 3 | | | | | 100% |
| 6 | Ерөнхий сайдын албан даалгавар | 1 | 1 | | | | | 100% |
| 7 | Сайдын тушаал | 5 | 5 | | | | | 100% |
| 8 | НДЕГ-ын даргын тушаал | 22 | 22 | | | | | 100% |
| 9 | НДЕГ-ын даргын албан даалгавар | 1 | 1 | | | | | 100% |
| **Нийт** | | | | | | | | **100%** |

ТАНИЛЦСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ДАРГА /Б.АНАР/

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН
МЭРГЭЖИЛТЭН /Д.ИДЭРЖАВХЛАН/